

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 339(517.3)
DOI 10.18101/2949-1657-2023-1-58-67

МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ЗӨВ СТРАТЕГИ ХУДАЛДААНЫ БОДЛОГООС ЭХЭЛНЭ

© Базарын Санжмятав

Олон улсын эдийн засгийн ухааны доктор

Монгол Улс, Улаанбаатар

b_sanjmyatav@yahoo.fr

Хураангуй. Уг өгүүлэлд Монгол Улсын гадаад худалдааны бодлогын хүрээнд хөгжих асуудлыг судлан анализ хийх зорилго тавьсан. ДХБ-ын гишүүн орнуудад олгож буй боломжуудыг судалж, хөрш орнуудтай хамтран бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцчлалын боломжийг судалж байна. Монгол Улс худалдааны бие даасан хуулийг баталж, холбогдох асуудлыг шийдвэрлэх чиглэлээр мэргэшсэн агентлаг байгуулж худалдааны олон талт тогтолцооны хүрээнд үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, шинээр үүсч бий болсон үйлдвэрлэлийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлаа сайжруулах боломжийг биелүүлэх ёстой гэж үзэж байна.

Түлхүүр үг: Монгол Улсын хөгжлийн стратеги, гадаад худалдаа, бүс нутгийн нэгдэл.

Ишлэл

Б. Санжмятав. Монголын хөгжлийн зөв стратеги худалдааны бодлогоос эхэлнэ // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2023; 1: (Орос хэл дээр). Х. 58–67.

Нэг. Худалдааны нэгдсэн бодлогоос хөгжлийн зөв стратегид

Олон талт худалдааны тогтолцоо нь гишүүн орнуудын хувьд ДХБ-ын хүрээнд боловсрогдон батлагдсан хэлэлцээрүүдийг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээлгэхээс гадна тэдгээр хэлэлцээрүүдээр олгогдсон боломж, давуу талуудыг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг. Тийм учраас улс орнууд хөгжлийн стратеги, бодлогоо боловсруулахдаа эхлээд худалдааны эрх зүйн орчныг судлаж, эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдсөн хэм хэмжээг, мөн бүс нутаг, хөрш орнуудаас тухайн орны хувьд бий болгож буй эрэлт хэрэгцээ, давуу талуудыг овсгоотой ашиглахад анхаардаг болно. Эл стратегийг олон улсын хэмжээнд “Grand Strategy” хэмээн нэрлэж байна. Азийн орнууд юуны өмнө Япон, БНСУ, Хятад зэрэг азийн орнууд дэлхий, бүс нутаг, хөрш орнуудын эрэлт хэрэгцээ, бий болсон боломжийг судлаж, энэ үндсэн дээр хөгжлийн стратегиа боловсруулж хэрэгжүүлсэн нь үсрэнгүй хөгжлийнх нь нэг үндсэн шалтгаан болжээ. Тийм ч учраас судлаач миний бие энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээ “Монголын хөгжлийн зөв стратеги худалдааны бодлогоос эхэлнэ” хэмээн нэрлэсэн болно.

Монгол Улс нь худалдаанаас хамгийн их хамааралтай орны нэг боловч худалдааны бие даасан хуульгүй, худалдааны нэгдсэн бодлого, нэгдсэн зохицуулалтгүй, худалдааг эрхлэх төрийн төв байгуулагагүй цөөн орны нэг болж байна. Дэлхий банкны тооцоолсноор, 2019 оны байдлаар Монгол Улсын худалдааны эргэлт нь ДНБ-ний 126%-тай тэнцүү байжээ. Энэ үзүүлэлт Хятадын хувьд 36%, Австралийн хувьд 46%, Оросын хувьд 49%, Шинэ Зеландын хувьд

56%, Казахсатаны хувьд 64%, дэлхийн дундач нь 60% байдаг ажээ¹. Олон улсын худалдаа нь ДНБ-ээс давсан байна гэдэг бол худалдаа эдийн засагт нэн чухал нөлөөтэй байгааг харуулж байгаа болно.

Монгол Улсад өнөөдөр худалдааны асуудлыг төрийн олон байгууллагад хуваан хариуцуулж байгаагаас нэгдсэн бодлого, зохицуулалтгүй явж ирсэн. Хуульд заасан чиг үүргийн дагуу УИХ нь худалдааны тарифын асуудлыг, Шадар сайд чөлөөт бүсийн асуудлыг, ГХЯ ДХБ-тай харилцах асуудлыг, СЯ гаалийн бодлогын асуудлыг, ХХААХҮЯ дотоод худалдааны асуудлыг, УУХҮЯ газрын баялгийн экспортын асуудлыг хариуцан ажиллаж байх жишээтэй. Мөн саянаас байгуулагдаж буй Эдийн засгийн хөгжлийн яам нь худалдааны бодлогын асуудлыг хариуцах чиглэлтэй байна.

Монгол Улсын худалдааны хуулийг төслийг 1990 оноос хойшхи хугацаанд хэд хэдэн удаа боловсруулж байсан боловч төсөл батлагдсангүй явж иржээ. Худалдааны хууль батлагдаагүй учраас худалдааны нэгдсэн зохицуулалт бий болоогүй, төрийн захиргааны төв байгуулагыг байгуулах асуудал шийдэгдэж байсангүй.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд хөгжиж буй орны статусаар элсэж, худалдаанд худалдааны олон талт тогтолцооны нийтлэг дүрэм, журмыг мөрдөх болсон. Учир нь ДХБ-ыг үндэслэн байгуулсан Марракешийн 1994 оны хэлэлцээрийн 2.1-т “ДХБ нь гишүүдийн хооронд худалдаа хийх нэгдсэн тогтолцоог бий болгоно”, 2.2-т “гишүүн орнууд Худалдааны олон талт хэлэлцээрүүдийг заавал дагаж мөрдөнө”² гэсэн заалттай. Мөн гишүүн орноос ДХБ-д элсэхдээ авсан үүрэг, амлалт нь худалдааны олон талт хэлэлцээрүүдийн бүрэлдэхүүн хэсэг болж заавал биелүүлэх үүрэг хүлээлгэдэг болно. Гэвч гишүүн орны Засгийн газруудад дотооддоо хөгжлийн болон худалдааны бодлогоо боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд эдийн засгийн үндсэн салбаруудаа хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бололцоог олгодог.

ДХБ-ын хүрээнд хүлээсэн үүргийн дагуу Худалдааны олон талт хэлэлцээрүүдийг өөрийн газар нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, үндэсний эдийн засгийн чухал салбаруудыг хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдийг бизнесийн орчинд сурталчлах, таниулах, хэрэгжүүлэх ажил өнгөрсөн хугацаанд хангалтгүй явж ирсэн байна. Энд юуны өмнө УИХ-аас Монгол Улс ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 тоот тогтоол хангалтгүй хэрэгжснийг онцлох хэрэгтэй юм. Эл тогтоолоор Засгийн газарт 5 төрлийн үүрэг өгөгдсөн боловч ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийг орчуулан хэвлэх, яамдын холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулахаас бусад ажил нь үндсэндээ хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Монгол Улсын хууль тогтоомжийг ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэн энэ он(1996)-д багтаан УИХ-д өргөн мэдүүлэх,

¹ URL: https://data.worldbank.org/indicator/NE.TRD.GNFS.ZS?name_desc=false&locations=MN.

² Олон улсын худалдааны хэлэлцээний Урагвай үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, УБ хот, 2000 он, 6 дугаар тал.

- ДХБ-ын Олон талт худалдааны хэлэлцээрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, тэдгээрт заасан мэдээ, мэдээллийг тогтмол гаргаж байх,

- ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ГХЯ-ны орон тоо, зохион байгуулалтад холбогдох өөрчлөлт оруулах

Дээрх тогтоолд заасан ёсоор ГХЯ-ны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулан олон улсын худалдааны асуудлыг эрхлэх хангалттай тооны орон тоог бий болгож, бэхжүүлж чадаагүй учраас Монгол Улсын хууль, тогтоомжийг ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдэд нийцүүлэн өөрчлөх, худалдааны мэдээллийн нэг цонхны үйлчилгээг бий болгох, худалдааны олон талт хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, эл тогтолцооны давуу талуудыг ашиглах асуудал хариуцах эзэнгүй үлджээ. Тийм ч учраас ДХБ-д Монголын худалдааны илтгэлийг 2021 онд авч хэлэлцэхэд НБДНГ-аас боловсруулсан илтгэлийн 3.56-д Монгол Улсад демпингийн эсрэг, саармагжуулах, хамгаалалтын арга хэмжээ авах тухай үндэсний хууль тогтоомж байхгүй, энэ асуудлыг хариуцах бүтэц төрийн нь албанд байхгүй тул бусад орнуудын эсрэг дээрх арга хэмжээг авч байгаагүй. Мөн илтгэлийн өөр нэг заалтад эл шалтгааны улмаас ямар ваа нэгэн оронтой маргаан үүсгэж байгаагүй гэж тусгажээ. Иймэрхүү заалтууд нь ДХБ-аар Монгол Улсын худалдааны илтгэлийг 2014 онд хэлэлцэхэд ч дурдагдаж байсан боловч Засгийн газраас арга хэмжээ аваагүй явж иржээ. Ийнхүү ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрээр гишүүн орнуудад олгодог таатай боломжуудыг Монгол Улс ашиглаж байсангүй. Үндсэн шалтгаан нь гэвэл УИХ-аас худалдааны хуулийн төслийг батлаагүй, энэ хуулиар холбогдох салбарын үйл ажиллагааны журмыг батлах эрхийг Засгийн газар олгоогүй, энэ асуудлыг эрхлэх төрийн бүтэц байхгүй байгаатай холбоотой байна¹.

Монгол Улсын зүгээс ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрийн дагуу ДХБ-ын НБДНГ-д гарган өгч байх ёстой мэдээллүүд ч тогтмол биш, бизнесийн хүрээнд олон талт худалдааны эрх зүйн талаар мэдээлэлгүй шахам байна. Монгол Улс 1997 онд ДХБ-д элсээд хүлээсэн үүргийнхээ дагуу худалдааны мэдээллийн нэг цонхны үйлчилгээг нээх ёстой байсан².

Засгийн газраас Худалдааны олон талт хэлэлцээрүүдийг орчуулан 2000 онд товхимол болгон хэвлэж, төрийн байгууллагуудын холбогдох хүмүүст тараасан, 2007 онд “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарын VII, VIII боть болгон хэвлэж, www.legalinfo.mn вэб хуудсанд байршуулжээ. Гэвч Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ хүлээсэн амлалт, үүргийг нарийвчлан заасан ДХБ-ын Монголыг тус байгууллагад гишүүнээр элсүүлэх Ажлын хэсгийн илтгэл³-ийг өнөөдөр хүртэл албан ёсоор хэвлээгүй үлдээжээ.

Монгол Улсын Хууль, тогтоомжийн тухай хуулинд зааснаар эрх зүйн баримт бичгүүд нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлд албан ёсоор хэвлэгдсний дараагаас дотоодод хэрэгжих эрх зүйн орчин бүрэлдэх ёстой. Ингэж үзвэл, ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүд нь дөнгөж 2007 оноос Монголд

¹ TPRB, TPR of Mongolia, Secretariat Report, 2014, 2021 www.wto.org

² Нэг цонхны мэдээллийн төвийг 2021 онд ГЕГ-ын дэргэд байгуулсан. БС.

³ Ажлын хэсгийн илтгэл нь батлагдмагц ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж, заавал биелүүлэх үүрэг хүлээлгэдэг. БС.

хэрэгжих нөхцөл бүрдсэн бол, ДХБ-ын Ажлын хэсгийн илтгэл дотоодод хүчин төгөлдөр болж чадаагүй байна.

Монгол Улсад ДХБ-ын “худалдааны олон талт хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллах бүтэц монголын төрд байхгүй” байгаа нь худалдааны нэгдсэн бодлогогүй, салбар хоорондын ажлын уялдаагүй, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх Үндсэн хуулийн заалт хэрэгжихгүй явж ирэх нөхцлийг бүрдүүлсэн гэж дүгнэх үндэстэй байна. Мөн дээрх шалтгаанаар Монгол Улс нь худалдааны олон талт тогтолцооны хүрээнд үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, шинээр үүсч бий болсон үйлдвэрлэлийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлаа сайжруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлын үед тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх эрх зүйн бололцоог ч ашиглаж чадаагүй болно.

Хоёр. ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдээр гишүүн оронд олгосон бололцоог ашиглах

ДХБ-ын хүрээнд бий болгосон олон талт худалдааны тогтолцоо нь нэг талаас гишүүн орнуудад хатуу үүрэг хүлээлгэх боловч үндэсний хэмжээнд зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, хөгжиж буй орнуудад нэн тулгамдсан эдийн засгийн аюулгүй байдал, юуны өмнө хүнсний аюулгүй байдлыг хангах, төлбөрийн тэнцлийн хэт алдагдлыг бууруулах зэрэг салбарт ашиглах томоохон боломжийг бий болгосон байдаг. Эдгээр бололцоог ашиглах нь тухайн гишүүн орон, төрийн бүтцийн мэдлэг, дипломат ажиллагаа, авхаалж самбаанаас нэлээнд хэмжээгээр шалтгаалдаг.

Монгол Улс ДХБ-д 1997 онд элссэн цагаас хойшхи хугацаанд дээрх бололцоонуудыг тун бага ашиглаж, олон тохиолдолд үндэсний эдийн засаг, үйлдвэрийн салбарт хохиролтой бодлого баримталж ирсэн. Энэ байдлыг зарим жишээн дээр авч үзвэл:

Тариф. Монгол Улс 1997 онд ДХБ-д элсэхийн тулд 260 гаруй бүтээгдэхүүний импортын тарифын асуудлаар 46 оронтой хоёр талын хэлэлцээг явуулсан ба эцсийн байдлаар импортод дунджаар 17.5 %-ийн тариф, түүний дотор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд 18.5%, хөдөө аж ахуйн бүс бүтээгдэхүүнд 17.3%-ийн тариф байхаар тохиролцож үүрэг, амлалт авсан нь харьцангуй доогуур үзүүлэлт болсон юм.

Монгол Улсаас ДХБ-д элсэхдээ авсан үүрэг, амлалтыг зарим орныхтой харьцуулбал:

Хүснэгт

Монгол улсын авсан орны үүрэг, амлалтыг зарим орныхтой харьцуулсан байдал¹

Улс	Тарифын үүрэг, амлалтын хэмжээ			Хэрэглэж буй тариф		
	Дундач тариф	ХАА-н бүтээгдэхүүн	ХАА-н бус бүтээгдэхүүн	Дундач тариф	ХАА-н бүтээгдэхүүн	ХАА-н бус бүтээгдэхүүн
Монгол	17.5	18.8	17.3	5.2	6.5	5.0
ОХУ	7.6	11.2	7.1	6.8	11.2	6.1
БНХАУ	10.0	15.7	9.1	9.8	15.6	8.8
Япон	4.7	19.3	2.5	4.4	15.7	2.5

¹ ДХБ-ын тарифын мэдээлэл үндэслэн боловсруулсан, БС.

БНСУ	16.5	58.0	9.8	13.7	57.0	6.7
Энэтхэг	50.8	113.1	36.0	17.1	38.8	13.6
ЕХ	5.1	12.8	3.9	5.2	12.0	4.2
Казахстан	6.5	10.0	6.0	6.4	9.6	5.8
Марокко	41.3	54.4	39.3	11.4	27.6	8.8
Вьетнам	11.7	18.8	10.5	9.5	16.5	8.4
Лаос	19.0	19.6	18.9	8.5	11.2	8.1
Киргиз	7.5	12.8	6.7	6.5	9.1	6.1

Эх булаг: ДХБ.

Монгол Улсын Засгийн газар нь хэрэглэж буй тарифын хэмжээг худалдааны бодлогынхоо хүрээнд дундач тарифын дээд хэмжээнд хүргэн нэмэгдүүлэх буюу бууруулах эрхтэй байдаг.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19-ийн цар тахлын нөхцөлд улс орнууд өдөр тутмын хэрэгцээт болон стратегийн, хүнсний чухал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өөрийн оронд байлгах, эс чадвал хөрш орноос импортолдог байх бодлогыг баримталж эхлээд байна. Энэ нөхцөлд Засгийн газраас өөртөө хэрэгцээтэй, бас өөрөө үйлдвэрлэж чадах бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийг дэмжиж эхэлсэн болно. Эл бодлого нь эх орондоо үйлдвэрлэх бүтээгдэхүүний ижил бүтээгдэхүүний импортыг хязгаарлах, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд импортын татварыг нэмэгдүүлэхээс эхэлнэ. Татварыг нэмэгдүүлэх хязгаар нь үүрэг амлалтын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй боловч шаардлагатай тохиолдолд, юуны өмнө хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг тохиолдолд дээрх түвшингээс ч илүүгээр нэмэгдүүлсэн байх боломжтой.

Монгол Улс НҮБ-ын ХХААБ-ын хүнсний дутагдалд орсон орны жагсаалтад, ДХБ-ын хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортоор авч байгаа орны жагсаалтад тус тус ороод олон жил болж байгаа боловч ХАА-н бүтээгдэхүүний импортод маш доогуур тариф баримталсаар байгаа нь үндэсний эрх ашигт нийцэхгүй байгаагийн нэг жишээ болно.

Монгол Улсын хэмжээнд мөрдөж буй импортын 5 хувийн нэгдсэн тариф нь үндэсний үйлдвэрийг гадаадын хямд, чанар муутай бүтээгдэхүүнээс хамгаалж чадахгүйгээр барахгүй, түүнийг сүйрүүлэх нөлөөтэй байгаа болно. Эл шалтгааны улмаас зах зээлийн харилцаанд шилжсэн жилүүдэд өмнөх тогтолцооны үед бий болсон үндэсний үйлдвэрлэл үндсэндээ устан үгүй болж, шинээр үйлдвэрүүд цөөн баригдсан юм. Ялангуяа Засгийн газраас 1997-1999 онд тарифыг тэглэж “тоглосон” нь үндэсний үйлдвэрт ихээхэн хохирол учруулсан.

Экспортын тарифын асуудлаар байгуулагдсан олон талт эрх зүйн зохицуулалт дэлхийн хэмжээнд одоогоор байхгүй боловч улс орнууд экспортын тарифыг экспортын бүтээгдэхүүний дотоодод боловсруулах түвшнийг дээшлүүлэх хөшүүрэг болгон ашигладаг. Гэтэл монголын экспортын бүтээгдэхүүний 90 гаруй хувь нь ухаад л ачсан газрын баялаг байхад Засгийн газраас экспортын тариф тогтоох талаар санаачилга гаргахгүй байна.

Тарифын бус арга хэмжээ нь олон улсын худалдаанд тарифаас илүү нөлөөлөх чадвартай, нуугдмал шинж чанартай байдаг онцлогтой. Эл утгаар ДХБ-аас тарифын бус арга хэмжээг аль болохоор бууруулах, тарифт шилжүүлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг баримталдаг болно.

Тарифын бус арга хэмжээнд

- тооны хязгаарлалт, хориг,
- экспорт, импортын татаас, дэмжлэг,
- демпингийн эсрэг арга хэмжээ,
- хамгаалалтын арга хэмжээ,
- саармагжуулах арга хэмжээ авах,
- техник, стандартын саад учруулах зэрэг арга хэмжээ орох

бөгөөд худалдааны олон талт хэлэлцээр, шийдвэрүүдэд авах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцлийг зааж өгсөн байдаг. Гэвч Монгол Улс нь худалдааны хуульгүй, Засгийн газраас дээрх асуудлыг хариуцах бүтцийг байгуулаагүй, хуулиар Засгийн газарт тодорхой эрхийг олгоогүй учраас эрх зүйн орчныг бүрэлдүүлж чадаагүй байна.

Тухайлбал Худалдааны олон талт хэлэлцээрийн 2 дугаар зүйлд хамгаалалтын арга хэмжээг авах үндсэн нөхцөл бол тухайн бүтээгдэхүүний импорт нь дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй нь харьцуулахад үнэмлэхүй буюу харьцангуй үзүүлэлтийн хувьд өсөн нэмэгдсэн хэмжээгээр импортлогдож байгаа бөгөөд чингэхдээ ижил бараа, эсхүл шууд өрсөлдөх чадавхи барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулж байвал хамгалалтын арга хэмжээ авч, тарифыг нэмэгдүүлэх эрхийг олгосон байдаг.

Демпингийн эсрэг хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд зааснаар импортын бүтээгдэхүүний үнэ нь экспортлогч орны дотоодын зах зээлд худалдаалагдаж байгаа ижил нэрийн барааны үнээс доогуур үнээр экспортлогдож байгаа нөхцөлд демпингийн эсрэг арга хэмжээг авах эрх зүйн орчныг бий болгосон.

Худалдааны олон талт тогтолцоонд экспортын бүтээгдэхүүнд засгийн газраас татаас олгохыг зарчмын хувьд хориглодог боловч тодорхой нөхцөлд түүнийг зөвшөөрөх буюу түүний сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээ авахыг зөвшөөрдөг болно. Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд татаасын эрх зүйн орчныг тодорхойлж, 3 дугаар зүйлд хориглосон татаасыг тогтоосон бол, өсөн нэмэгдсэн импорт нь дотоодын үйлдвэрлэл, зах зээлд сөргөөр нөлөөлж байгаа бол ТХЕХ-ийн 19, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 5,6 дугаар зүйлд, мөн ХАА-н хэлэлцээрийн 5 дугаар зүйлд саармагжуулах арга хэмжээ авахыг зөвшөөрсөн байдаг.

Хөгжлийн судлаачдын үзэж байгаагаар хөгжлийг санхүүжүүлэгч эх үүсвэрийг бүрдүүлэгч нь үндэсний аж үйлдвэр байдаг байна. Гэтэл Монгол Улс газрын баялгаа ухаад, мал аж ахуйн гаралтай түүхий эдээ түүхий хэлбэрээр нь экспортолж байгаа нь үндэсний эрх ашигт мөн нийцэхгүй байгаа юм. Тийм учраас эдийн засгаа олон тулгууртай болгох, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах, нэмэгдэл өртөг илүү шингээх, экспортын бүтээгдэхүүний оврыг бууруулах, тээвэр ложистикийн бүтцийг байгуулах бодит шаардлага байгаа болно. Энэ үүднээс ирээдүйтэй, давуу талтай салбаруудыг сонгож, үндэсний үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх нь төрийн бодлогын үндэс байх ёстой байна. Худалдааны олон талт тогтолцоонд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, шинээр үүсч байгаа салбаруудыг хөл дээр зогсох хүртэл дэмжих, эдийн засаг,

хүнсний аюулгүй байдлаа хангах зэрэг чиглэлээр арга хэмжээ авахыг зөвшөөрсөн байдаг.

Импортын бүтээгдэхүүнд техник, стандартын шаардлагыг тавьж мөрдүүлэх нь тухайн орны эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, хэрэглээний стандартыг хангах зорилготой.

Үнийн зохицуулалт нь худалдааны бодлогын бас нэг хэрэгсэл болдог. Өндөр хөгжсөн, зах зээлийн эдийн засагтай орнуудад ч тодорхой салбаруудад үнийн зохицуулалтыг хатуу хэрэгжүүлдэг болно. Тухайлбал, ард түмний өдөр тутмын өргөн хэрэглээний бараа, эмийн худалдааг бизнесийн салбар гэж үздэггүй бөгөөд энд зарагдах барааны үнийн дээд хэмжээг улсаас тогтоон өгч, орон даяр нэг маягаар мөрдүүлдэг. Эдгээр салбарт дамжлага тус бүрд ашгийн хэмжээг дунджаар 10%-иар тогтоож, шат тус бүрд нь үнийг нь хянаж байдаг. Ард түмний эрүүл мэндийг хамгаалах шалтгаанаар архи, тамхины онцгой татварыг тогтоож, хэрэглээг хязгаарладаг. Шатахуун, цахилгааны үнийн өсөлтийг ч тусгай журмын дагуу дагуу зохицуулж байгаа нь ядуу, дунд давхаргын хэт ачааллыг бууруулах, хамгаалах бодлогын хэрэгсэл болгодог байна.

Энэ мэтээр худалдааны олон салбарт Худалдааны олон талт тогтолцооны эрх зүйн хэм хэмжээгээр зөвшөөрөгдсөн арга хэмжээг авах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, дотоодын зах зээлээ хамгаалах арга хэмжээг авах бололцоо байгаа боловч Монгол Улсад худалдааны хуульгүй, Засгийн газарт хуулиар эрх олгоогүй болох тул холбогдох журмууд батлагдаагүй, арга хэмжээ авч чадахгүй явж байна.

Монгол Улс Худалдааны олон талт тогтолцоонд хөгжиж буй орны статустай элсэн орсон тул үйлчилгээний худалдааны хэлэлцээрийн заалтуудыг хатуу мөрдөх үүрэг хүлээхгүй. Энэ утгаар авч үзвэл үйлчилгээний, банк, санхүүгийн салбарт хязгаарлалт тогтоох, үйлчилгээний байгууллагууд, юуны өмнө өөрсдөө аваад явж чадах, бас түргэн орлогоо өгдөг түргэн хоол, дэлгүүр, рестораны сүлжээ зэрэг салбарт гадаадын компанийн үйл ажиллагаа явуулах хязгаарлалт(зах зээлийн тодорхой хувиас хэтрэхгүй байх, хамтарсан компани болж ажиллах зэрэг)-ыг тогтоох бололцоо байгаа.

Худалдааны олон талт тогтолцооны Төлбөрийн тэнцэлтэй холбогдсон харилцан ойлголцлын баримт бичигт ч төлбөрийн тэнцлийн хүндрэлд орсон нөхцөлд Засгийн газраас олон арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн байдаг.

Гурав. Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци

Сүүлийн олон жилийн туршид дэлхийн эдийн засгийн даярчлал үндсэндээ зогсонги байдалд орж, “хүйтэн дайн”-ы уур амьсгал сэргэж, “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр дэлхийн нэмэгдсэн өртгийн сүлжээ(GVC) ажиллахгүй болсон нөхцөлд эдийн засгийн хөгжлийн үндсэн хандлага бол бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци болж байна.

Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци нь худалдаа, эдийн засгийн хамгийн таатай орчин болдог. Учир нь энд оролцогч талуудын нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нөгөө орны нутаг дэвсгэрт татваргүй орох бололцоогоор хангагдаж, хил гаалийн хүнд суртлууд арилж, нэгдмэл стандартууд хэрэгжихээс гадна тээвэр, ложистикийн нэгдсэн бүтцүүд үүсэх нь хамтын ажиллагааг ихээхэн хөнгөвчилдөг болно.

Энэ нөхцөлд улс орнууд үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлж, өдөр тутмын хэрэгцээт, стратегийн, хүнсний чухал бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэх, боломжгүй бол ядаж хөрш орноосоо авах бодлогыг баримталж эхлээд байгааг өмнө дурдсан билээ. Энэчлэн хөрш зэргэлдээ, бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа идэвхижиж, үйлдвэрлэл, үйлчилгээ, түүхий эд, ажиллах хүчний нэгдсэн боложиндоо түшиглэн **хамтран хөгжих** үзэл санаа улам бүр түгээмэл болж байна. Энэ нөхцөл нь улс орнуудын зүгээс урт хугацааны хөгжлийн стратегиа шинэчлэн боловсруулах, хөгжлийн бодлогоо уялдуулахыг шаардах болно.

Монгол Улс нь бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцид хамгийн сул хамрагдсан орны нэг болно. Өнөөдрийн байдлаар Монгол Улс Японтой Эдийн засгийн хэлэлцээрийг 2016 онд байгуулсан, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2020 онд нэгдсэн байна.

Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь Монголын хувьд үр дүнгүй болсон. Энэ нь олон улсын худалдааны онолоор өндөр хөгжсөн ба ядуу орнууд ЧХХ байгуулбал хөгжиж буй оронд ашиггүй байдаг гэсэн үзэл баримтлалтай, мөн монголын тал хэлэлцээг муу явуулсантай холбоотой болно.

Монгол Улсын Засгийн газар БНСУ-тай ЭЗТХ, БНХАУ-тай ЧХХ байгуулах асуудлыг судлаж байгаа боловч тэдгээрээс Монголын тал томоохон ашиг хүлээхэд бэрхшээлтэй байх юм. Харин Засгийн газраас Евразийн эдийн засгийн холбоотой ЧХХ байгуулбал ашигтай байх боломжтой болохыг судалгаагаар тогтоосон байдаг¹.

Монгол Улсаас бүс нутгийн интеграцид хамрагдах нэг гол чиглэл бол Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорыг байгуулах явдал болно. Орос, Монгол, Хятадын гурван талт дээд хэмжээний 2015 оны Уфагийн уулзалтаас гурван орны эдийн засгийн коридорыг байгуулах талаар эцэслэн тохиролцож, 2016 оны Ташкентийн уулзалтаас эл хамтын ажиллагааны төлөвлөгөө болох “Замын зураг(Road Map)-ийг баталж, эхний ээлжинд хэрэгжүүлэх 32 төслийг сонгож, хамтын ажиллагааны төслүүдийг боловсруулж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилготой гурван орны “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв”-ийг Улаанбаатарт байгуулахаар шийдвэрлэж, хамтын ажиллагааны асуудлыг хариуцан ажиллах байгууллагуудыг томилсон. Тийм байгууллагаар монголын талаас ГХЯ, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, хятадын талаас Хөгжил, шинэтгэлийн хороог томилсон болно.

Гурван талаас хэрэгжүүлэхээр сонгож авсан 32 төслөөс хэрэгжих шатандаа орсон төсөл гэвэл ОХУ-аас Монголын нутгаар дамжуулан Хятад руу байгалийн хий дамжуулах хоолойг барьж байгуулах төсөл болно. Энэ төслийн Монголын нутгаар дамжин баригдах хийн хоолойн анхны ТЭЗҮ-ийг монгол, оросын талууд боловсруулж дуусгаад, төслийг хэрэгжүүлэх нэгжийг Монголд байгуулсан байгаа боловч хятадын талаас эцсийн шийдвэрээ хэлээгүй байгаа юм.

Мөн гурван орон авто замын тээвэр, төмөр замыг хөгжүүлэх, аялал жуулчлалын нэгдсэн сүлжээг бий болгох, хил гаалийн процедурыг нэгтгэх асуудлуудаар холбогдох хэлэлцээрүүдийг байгуулсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

¹ Доктор Б. Санжмятав нарын багаас хийсэн.

Гурван орон худалдааг хөнгөвчлөх асуудлаар чармайлт гаргаж байгаа боловч тодорхой үр дүн бага байна. Ялангуяа “Ковид-19” цар тахлын нөхцөлд хорио цээр, тээвэр ложистикийн бэлэн бус байдлаас шалтгаалан Монголын худалдаанд ихээхэн бэрхшээл учирч байна. Энд гурван орны хөгжлийн бодлогын уялдаа чухал үүрэгтэй болохыг амьдрал харуулж байна. Тухайлбал, Монголын тал Замын Үүд, Цагаан нуур, Алтанбулагийн чөлөөт бүсийг байгуулах талаар хэдэн арван жил ярьж байгаа боловч бодтойгоор хэрэгжсэн зүйл бага байгаа нь хөрш орнуудтайгаа бодлогоо уялдуулж чадахгүй байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Монгол, Хятадын Засгийн газар хооронд Замын Үүд, Эрээний хил дамнасан чөлөөт худалдааны бүсийг байгуулах хэлэлцээрт 2019 онд гарын үсэг зурсан боловч УИХ уг хэлэлцээрийг батлалгүй нэлээд хугацаанд дарж байснаас шалтгаалан дөнгөж одооноос хэрэгжих эрх зүйн орчин бүрдэж байна.

Хөрш орнуудтай худалдааг хөгжүүлэх, хил гаалийн хүнд суртлыг арилгах, тээвэр, ложистикийн нэгдсэн сүлжээг үүсгэхэд урт хугацааны бодлогын уялдаа нэн чухал шаардлагатай байна. Монголын талаас Алтанбулаг, Цагаан нуурын чөлөөт бүсийг байгуулах асуудлаар Оросын талтай хэлэлцээг эхлүүлээгүй явж иржээ. Засгийн газар 2021 оны эцсээр Эдийн засгийн шинэ сэргэлтийн бодлогоо УИХ-д танилцуулж, бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг нь боомтын сэргэлт байхыг зарлав. Гэтэл Хятад Улс эдийн засгаа хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөөгөөг 2021 оны эхээр баталсан ба энд Монголтой хил нийлсэн боомтыг сэргээх асуудал тусгагдаагүй байна. Мөн төмөр замын шинэчлэлийн асуудлаар ч гэсэн хөрш орнуудтай бодлогын түвшинд тохиролцож, тээвэрлэх ачаа барааг нэмэгдүүлэх талаар баталгааг авахгүй бол хөрөнгө оруулалтаас үр дүн гарахгүй.

Ийнхүү дээр өгүүлснээс дүгнэж үзэхэд, худалдааны тухай хуулийг баталж, бодлогоо тодорхой болгосон, эл асуудлыг хариуцах төрийн захиргааны төв байгуулагыг байгуулсан тохиолдолд л хөгжлийн стратеги зөв замд орж, хэрэгжих бололцоотой болно гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

Ашигласан зохиол

1. Олон улсын худалдааны хэлэлцээний Урагвай үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд. Улаанбаатар, 2000. 271 т. (Юридические документы, заключенные по итогам Уругвайского раунда международных торговых переговоров. Улан-Батор, 2000. 271 с.)
2. Trade (% of GDP) – Mongolia. URL: https://data.worldbank.org/indicator/NE.TRD.GNFS.ZS?name_desc=false&locations=MN.
3. TPRB, TPR of Mongolia, Secretariat Report, 2014, 2021 www.wto.org.
4. Сянжмятав Б. Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийн эмхэтгэл). Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр, 2021. 286 т.

Тус өгүүлэл 2023 оны 1-р сарын 12-ны өдөр редактор хүлээн авсан; 2023 оны 1-р сарын 24-ний өдөр хэлэлцээд баталсан; 2023 оны 1-р сарын 26-нд хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

TRADE POLICY AS A BASIS FOR THE CORRECT
DEVELOPMENT STRATEGY OF MONGOLIA

Bazaryn Sanzhmyatav

PhD (International Economy), Independent Expert,
Mongolia, Ulaanbaatar
b_sanjmyatav@yahoo.fr

Abstract. The article discusses the ways of Mongolia's development within the framework of its foreign trade policy. We have analyzed the possibilities provided to the WTO member countries, as well as the potential of regional trade and economic integration in cooperation with neighboring states. It is concluded that the development strategy will be effectively implemented only if the Law on Trade is adopted and a specialized agency is created to address related issues.

Keywords: development strategy, foreign trade, regional integration of Mongolia.

For citation

Sanzhmyatav B. Trade Policy as a Basis for the Correct Development Strategy of Mongolia. *Oriental Vector: History, Society, State.* 2023; 1: 58–67 (In Russ).

The article was submitted 12.01.2023; approved after reviewing 24.01.2023; accepted for publication 26.01.2023.